Төвийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн, чанарын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн менежментийн тогтолцооны ISO 9001:2015, ISO 45001:2018 стандартуудыг хэрэгжүүлэн, эрсдэлийг бууруулан, үйлчлүүлэгч, ажиллагсдад ээлтэй орчныг бүрдүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Донорын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үндэсний хэмжээнд чанар, аюулгүй байдлыг бүрэн хангасан цус, цусан бүтээгдэхүүнээр хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын багц хууль шинээр батлагдсан;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт орсон;
- Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт орсон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагаанд төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” шинээр батлагдсан;
- Засгийн газрын 2024 оны 128 тогтоолоор баталсан “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” шинээр батлагдсан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цус сэлбэлт, судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг төвийн захирлын 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/51 тоот тушаалаар батлан мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,805,844.5 мянган төгрөгөөр буюу 19.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	180.0	-	(180.0)
Авлага	1,653,877.9	4,631,569.8	2,977,691.9
Урьдчилгаа	7578.5	4649.5	(2,929.0)
Бараа материал	6,048,588.7	4,755,945.7	(1,292,643.0)
Үндсэн хөрөнгө	6,495,025.7	7,618,930.3	1,123,904.6
Нийт хөрөнгө	14,205,250.7	17,011,095.3	2,805,844.5
Өр төлбөр	212,489.8	2,189.7	(210,300.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	13,992,760.9	17,008,905.5	3,016,144.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,205,250.7	17,011,095.3	2,805,844.5

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлгүй байна. Авлагын дансны үлдэгдэл 4,631,569.8 мянган төгрөг болж, 2,977,691.9 мянган төгрөгөөр өссөн нь захиалагч байгууллагууд цус, цусан бүтээгдэхүүний төлбөрийг төлж чадахгүйгээс үүссэн авлага 60.7 хувийг, нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулахаар баталж тооцоо нийлсэн авлага 38.4 хувийг эзэлж байна. Захиалагч байгууллагуудаас авах авлагын ихэнхийг Улсын нэгдүгээр төв эмнэлэг 794,875.0 мянган төгрөг, Эх хүүхдийн эрүүл, мэндийн төв 482,380.0, мянган төгрөг, Гэмтэл, согог, сэргээн засах клиник эмнэлэг 468,537.0 мянган төгрөгийн авлагууд эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,755,945.7 мянган төгрөг болж 1,292,643.0 мянган төгрөгөөр буурсан нь хэрэгцээ шаардлагаас шалтгаалан эм, эмнэлгийн хэрэгсэл, шаардлагатай багаж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, шинжилгээний урвалж оношлуур, эмнэлгүүдэд олгох цус, цусан бүтээгдэхүүн, улсын нөөцөд шаардлагатай бүтээгдэхүүн зэрэг бараа материалын нөөцийг зөв, оновчтой байлгах, багасгах чиглэл баримталж ажилласантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,618,930.3 мянган төгрөг болж 1,123,904.6 мянган төгрөгөөр өссөн нь Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/153 дугаар тушаалаар 137,203.1 мянган төгрөг, бусад байгууллагаас 110,700.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжин ирж, өөрийн хөрөнгөөр 49,165.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, ТӨБЗГ-ын шийдвэрээр 1,146,573.8 мянган төгрөгийг акталж, 3,343,547.5 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 230 нэр төрлийн үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгийг зарлага болгон цаашид ашиглах боломжтой хөрөнгийг шинээр үнэ тогтоож 1,750,138.1 мянган төгрөгөөр бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна.

Тайлант хугацаанд 922,536.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан бөгөөд акталсан хөрөнгийн элэгдэл 1,145,808.1 мянган төгрөг байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 2,189.7 мянган төгрөг болж, 210,300.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 17,008,905.5 мянган төгрөг болж 3,016,144.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүн 3,016,144.6 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төв 2024 оны төсвийн төсөлд өөрийн орлогоос 3,090,000.0 мянган төгрөг, улсын төсвөөс 10,544,995.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр тооцож нийт орлогыг 13,634,995.9 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийг төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтийг 4,419,990.0 мянган төгрөг, өөрийн орлогыг 610,854.0 мянган төгрөг, нийт 5,030,840.0 мянган төгрөг бууруулж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/546 дугаар тушаалаар төсвийг 8,604,151.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төвийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 2,479,146.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2024 онд Сангийн сайдын 224 дугаар тушаалаар давсан орлогоос 2,628,367.4 мянган төгрөгийг зарцуулах эрх олгосон нь төлөвлөсөн орлогоос 106 хувиар илүү байгаагаас үзэхэд үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 6,123,906.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 605,146.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээр 5,518,760.4 мянган төгрөгийн санхүүжилтийг тайланд тусгасан, үндсэн үйл ажиллагааны орлого 2,971,110.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 3,418.0 мянган төгрөг, нийт 8,493,288.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн ажилласан байна.

Гүйцэтгэлээр зарцуулсан 8,493,288.9 мянган төгрөгийн зардал нь төлөвлөсөн зардлаас 110,863.0 мянган төгрөгөөр буюу 1.29 хувиар хэмнэсэн нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 107,679.6 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгааны зардлыг 13.5 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 1,394.9 мянган төгрөг, хөтөлбөр төслийн дотоод урсгал зардлыг 1,595.0 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Цус сэлбэлт, судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн аудит,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	5,709,489.9	5,601,810.3	107,679.6	98.1
2	80205 Мэдээлэл сурталчилгааны зардал	3,313.5	3,300.0	13.5	99.6
3	80219 Харуул, хамгаалалтын зардал	53,486.0	53,486.0		100.0
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулах, дэмжлэг	25,038.1	23,643.2	1,394.9	94.4
5	81611-Төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээ	2,771,181.9	2,771,181.9		100.0
6	83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	41,642.5	40,047.5	1,595.0	96.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансанд тайлант онд өмнөх оны авлага /давсан орлогын үлдэгдэл/ 497,221,3 мянган төгрөг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 13,582.5 мянган төгрөг, төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал 6,918.4 мянга төгрөг, Онцгой байдлын ерөнхий газраас 12,000.0 мянган төгрөг, Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 224 дугаар тушаалаар олгогдсон тайлан оны давсан орлого 2,628,367.4 мянган төгрөг, нийт 3,158,089.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, зориулалтын дагуу эрх нээлгэн 1,375,715.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулаагүй үлдэгдэл 1,782,374.1 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 1,777,913.1 мянган төгрөгийг авлагаар бүртгэж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төв нь 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 6 арга хэмжээнд 6,490,738.2 мянган төгрөгийн төлөвлөгөө батлуулан цахим системд байршуулснаас 5 арга хэмжээнд 59 аж ахуйн нэгж байгууллагатай 5,968,393.8 мянган төгрөгийн гэрээ байгуулж 99.7 хувиар биелүүлсэн байна. Азифарма бараа тасарсан шалтгаанаар гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цус сэлбэлт, судлалын үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төвийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян суварга Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Гантуяа, аудиторын туслах Э.Нарантуяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Г.Мөнхзул, захирал С.Должинсүрэн, дараагийн шатны чанарын хяналтыг Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Б.Отгонцэцэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 16,211,087.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 162,110.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 113,477.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус төв нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор жил бүр төлөвлөгөө боловсруулан ерөнхий захирлаар батлуулан мөрдөж ажилласан байна.

Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласнаар цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 35,090.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 23,688.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 35,714.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 1,829.1 мянган төгрөг, норматив зардлыг 2,611.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 7,218.5 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 958.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 583.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,595.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 1,394.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 113,729,835.3 мянган төгрөгийн 210 гүйлгээг, зарлагын 7,030,255.7 мянган төгрөгийн 147 гүйлгээг, тендер шалгаруулах, худалдан авах ажиллагаатай холбоотой 6,200,455.1 мянган төгрөгийн 13 гүйлгээг хуулийн хугацаанд тус тус мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Цус, сэлбэлт судлалын үндэсний төвийн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгадагч байгууллагын 2024 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, горим сорил хэрэгжүүлсний үр дүнд нийт 622,856.5 мянган төгрөгийн 7 асуудлыг илрүүлж асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 578,987.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, биелэлт хангалтгүй хоёр асуудлыг жилийн эцсийн аудитын тайланд тусгав.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 54,553.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 27,459.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг 64.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	4	54,553.0	3	31,113.1	57.0
Зөвлөмж	3	27,459.9	2	19,500.0	71.0
Нийт дүн	7	82,010.9	5	50,613.1	64.0

Өмнөх оны аудитаар өгсөн авлагын тооцоо нийлээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, мөн тайлант онд төсөвт өртгийг хуваан, шууд худалдан авалт гүйцэтгэсэн зөрчилд өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй давтан гаргасан тул зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цус цусан бүтээгдэхүүний үндэсний төв нь 2024 онд үйл ажиллагааны орлогоор нийт 5,599,477.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс Сангийн сайдын 224 дугаар тушаалаар давсан орлогоос 2,628,367.4 мянган төгрөг зарцуулах эрх олгосны дагуу нэмэлт дансанд шилжүүлэхдээ орлого бууруулах бичилт хийж, төсвийн гүйцэтгэлийн тайланд үйл ажиллагааны орлого бодит гүйцэтгэлээр биш зарцуулах эрх олгосон давсан орлогыг хассан дүн 2,971,110.5 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Энэ нь дараа жилийн төсвийн төлөвлөлтөд сөргөөр нөлөөлж байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 49,516.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 43,868.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 5,648.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа нь 49,516.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 162,110.9 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт

1. Харилцагч байгууллагуудаас авах 4,371.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, 20.2.6 -д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгсөн.

Илрүүлэлт:

2. Цусны донорт зориулсан багц худалдан авах 39,497.4 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ тендер шалгаруулалт эхлээгүй нэрийдлээр хоёр өөр байгууллагатай гэрээ байгуулж шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага өгсөн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу тайлагнаагүй, хог хаягдал зайлуулах ариутгалын зардалд 5,648.2 мянган төгрөгийн цэвэрлэгээний зардал тусгасан байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын Хоёр: 213107 “хог, хаягдал зайлуулах ариутгалын зардлын ангиллын тайлбар;-тай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн урсгал зардлын эдийн засгийн ангиллыг төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахад мөрдөж ажиллах;

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Бараа, материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Бараа, материалын эхний хагас жилийн тооллогыг зохих журмын дагуу явуулж тооцоо бодоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/" гэсэн заалттай нийцээгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа, материалын тооллогыг хагас жил, бүтэн жилээр хийж тооллого хийх хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах ;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн зарлагыг эдийн засгийн ангиллын дагуу тайлагнаагүй, хог хаягдал зайлуулах, хортон шавж ариутгалын зардалд 5,648.2 мянган төгрөгийн цэвэрлэгээний материалын зардал тусгасан байна.	1	5,648.2					1	5,648.2				
Харилцагч байгууллагуудаас авах 556,088.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	4,371.3			1	4,371.3						
Бараа материалын эхний хагас жилийн тооллогыг хуулийн дагуу хийгээгүй байна.	1	-					1					
Цусны донорт зориулсан багц худалдан авах 39,497.4 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ тендер шалгаруулалт эхлээгүй нэрийдлээр хоёр өөр байгууллагатай гэрээ хийж шууд худалдан авалт хийсэн байна.	1	39,497.4			1	39,497.4						
Дүн	4	49,516.9			2	43,868.7	2	5,648.2				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 140/A015185

Улаанбаатар хот

СНАГ-2025/289/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны харьцуулалтын аргаар тендер зарлаж худалдан авах боломжтой 39,497,400.00 /Гучин есөн сая дөрвөн зуун ерэн долоон мянга дөрвөн зуун төгрөгийн худалдан авалтыг хэсэгчлэн хувааж шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", 24 дүгээр зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.1.11-т хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал /Н.Эрдэнэбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Х.Одгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН СУВАРГА АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

С.ДОЛЖИНСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 41/2015185

Улаанбаатар хот

СНАГ-2025/089/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллага, хувь хүмүүстэй холбоотой авлагын 4,371,300.00 /Дөрвөн сая гурван зуун далан нэгэн мянга гурван зуун/ төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал /Н.Эрдэнэбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Х.Одгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН СУВАРГА АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

С.ДОЛЖИНСҮРЭН